



“ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР”- ЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Захиалагч:

Гадаадын Иргэн, Харьяатын Газар

Гүйцэтгэгч:

“Эс Ай Си Эй” ХХК

2024

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ТАЛАРХАЛ.....	6
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	8
1.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	8
1.3 ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ	8
1.4 ТАЙЛАНД ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГУУД	9
1.5 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН АРГА	10
1.6 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ	10
1.7 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	10
БҮЛЭГ II. ГИХГ-ААС ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ИРГЭД ААНБ-ЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ	13
2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	13
2.2 СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	15
2.2.1 ГИХГ-ын үйлчилгээний төрөл болон шаардлага	15
2.2.2 Мэдээллийн хүртээмжтэй байдал	31
2.2.3 Байгууллагын үйлчилгээний орчин	34
БҮЛЭГ III. АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ	37
3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	37
3.2 СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	39
3.2.1 Албан хаагчдын ажлын ачаалал	40
3.2.2 Албан хаагчдын сэтгэл ханамжтай байдал	41
3.2.3 Дээд албан тушаалтны харилцаа хандлага болон ур чадвар	42
3.2.4 Байгууллагын дотоод орчны үнэлгээ	44
ДҮГНЭЛТ	52
ГИХГ-аас үйлчилгээ авсан иргэд ААНБ-ын судалгааны дүгнэлт	52
Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт	54
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	56
ХАВСРАЛТ	58

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хуваарилалт.....	8
Хүснэгт 2. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа , үйлчилгээний төрлөөр ...	18
Хүснэгт 3. Үйлчилгээг сайжруулахад шаардлагатай ажлын санал, үйлчилгээний төрлөөр	30
Хүснэгт 4. Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүд	39
Хүснэгт 5. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн үнэлгээ, ажилчдын албан тушаалаар	47
Хүснэгт 6. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн үнэлгээ, ажиллаж буй байршлаар	47
Хүснэгт 7. Хүндрэл бэрхшээл, эрхэлж буй албан тушаалаар	48
Хүснэгт 8. Хүндрэл бэрхшээл, ажиллаж буй байршлаар.....	49
Хүснэгт 9. Албан хаагчдын судалгааны түүврийн задаргаа	58
Хүснэгт 10.. Үйлчилгээ авсан иргэн, ААНБ-ын түүврийн задаргаа	58

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Мэдээлэл цуглуулах аргууд.....	10
Зураг 2. Мэдээлэл цуглуулалтын хяналтын үе шатууд.....	10
Зураг 3. Судалгаанд оролцогчдын байршил, heat map.....	15
Зураг 4. ГИХГ-ын үйлчилгээний төрлүүд	16

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Үйлчлүүлэгчдийн төрөл	13
График 2. Судалгаанд оролцогчдын хүйс насны бүтэц.....	13
График 3. Судалгаанд оролцогчдын	
График 4. Судалгаанд оролцогчдын насны бүтэц , хүйсээр.....	14
График 5. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал	14
График 6. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого	14
График 7. Судалгаанд оролцогчдын оршин суудаг байршил	15
График 8. Судалгаанд оролцогчдын авсан үйлчилгээний төрөл.....	15
График 9. Үйлчлүүлэгчдийн төрөл, авсан үйлчилгээний төрлөөр	16
График 10. ГИХГ-аас авсан үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь.....	17
График 11. ГИХГ-аас авсан үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь, үйлчлүүлэгчдийн төрлөөр	17
График 12. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа.....	18
График 13. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа, үйлчлүүлэгчдийн төрлөөр	18
График 14. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал.....	19
График 15. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал, үйлчлүүлэгчдийн төрлөөр	20
График 16. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал, үйлчилгээ тус бүрээр харвал	20
График 17. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх.....	21
График 18. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх, үйлчлүүлэгчдийн төрлөөр ..	21
График 19. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх, үйлчилгээний төрлөөр	22
График 20. ГИХГ-с үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл гарсан эсэх	22
График 21. Үйлчилгээ авахад гарсан хүндрэл.....	23
График 22. Үйлчилгээ авахад гарсан хүндрэл, үйлчилгээний төрлөөр.....	24
График 23. Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ	24
График 24. Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр.....	25
График 25. Харьяатын чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ	26
График 26. Харьяатын чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр.....	26
График 27. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ	27
График 28. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр.....	27
График 29. Цахим үйлчилгээний чанарын үнэлгээ	28
График 30. Цахим үйлчилгээ авахад гардаг хүндрэл бэрхшээл.....	28
График 31. Хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэх.....	29
График 32. График 33. Хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэх, үйлчлүүлэгчдийн төрлөөр.....	29
График 34. Үйлчилгээг сайжруулахад шаардлагатай ажлын санал.....	30
График 35. Судалгаанд оролцогчдын ГИХГ-ын талаарх мэдлэг	31
График 36. ГИХГ-ын талаарх мэдлэг, үйлчлүүлэгчдийн төрлөөр.....	31
График 37. Мэдээллийн хүртээмжтэй байдал	32
График 38. Мэдээллийн хүртээмжтэй байдал, үйлчлүүлэгчдийн төрлөөр	32
График 39. Мэдээллийг ямар нэмэлт эх сурвалжаар авмаар байгаа санал	33
График 40. Үйлчилгээний хүртээмжтэй байдал.....	33
График 41. Үйлчилгээний хүртээмжтэй байдал, үйлчилгээний төрлөөр.....	33
График 42. Албан хаагчдын ёс зүйн үнэлгээ	34
График 43. Албан хаагчдын ёс зүйн үнэлгээ, үйлчилгээний төрлөөр	34
График 44. Үйлчилгээний орчны үнэлгээ	35
График 45. Зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааны үнэлгээ	35

График 46. Судалгаанд оролцогчдын албан тушаал.....	37
График 47. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй байршил.....	37
График 48. Судалгаанд оролцогчдын хүйс нас	График 49. Судалгаанд оролцогчдын 38
График 50. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	38
График 51. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого.....	38
График 52. Судалгаанд оролцогчдын тус байгууллагад ажиллаж буй хугацаа.....	39
График 53. Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүдийн дундаж оноо.....	39
График 54. Ажлын ачааллын үнэлгээ	40
График 55. Ажлын ачааллын үнэлгээ, ажиллаж буй байршлаар	40
График 56. Ажлын ачааллын үнэлгээ, эрхэлж буй албан тушаалаар.....	41
График 57. Сэтгэл ханамжтай байдал	41
График 58. Сэтгэл ханамжтай байдал, эрхэлж буй албан тушаалаар.....	41
График 59. Сэтгэл ханамжтай байдал, ажиллаж буй байршлаар	42
График 60. Дээд албан тушаалтны харилцаа хандлагын үнэлгээ	42
График 61. Дээд албан тушаалтны харилцаа хандлага, эрхэлж буй албан тушаалаар	42
График 62. Дээд албан тушаалтны харилцаа хандлага, ажиллаж буй байршлаар	43
График 63. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ.....	43
График 64. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ, эрхэлж буй албан тушаалаар	43
График 65. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ, ажиллаж буй байршлаар.....	44
График 66. Байгууллагын дотоод уур амьсгал.....	44
График 67. Байгууллагын дотоод уур амьсгал, эрхэлж буй албан тушаалаар	45
График 68. Байгууллагын дотоод уур амьсгал, ажиллаж буй байршлаар	45
График 69. Байгууллагын дотоод орчин	45
График 70. Байгууллагын дотоод орчин, ажиллаж буй байршлаар	46
График 71. Байгууллагын дотоод орчин, эрхэлж буй албан тушаалаар.....	46
График 72. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн дундаж үнэлгээ..	46
График 73. Хүндрэл бэрхшээл	48

ТАЛАРХАЛ

Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК нь “Гадаадын Иргэн, Харьяатын Газар”-ын захиалгаар “Гадаадын Иргэн, Харьяатын Газрын хэрэглэгчийн үнэлгээг ажил”-ыг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлыг амжилттай зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичгээр хангаж, санал бодлоо хуваалцан хамтран ажилласан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс Хяналт-шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Нямцэцэг болон орон нутгийн боомтуудын ахлах байцаагч нарт талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ БАГ БҮРЭЛДЭХҮҮН:

Багийн ахлагч

Г.Эрдэнэ

“Эс Ай Си Эй” ХХК-ийн Дэд захирал

Дүн, шинжилгээний баг

Т.Түмэнчимэг

“Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны хэлтсийн захирал

Мэдээлэл цуглуулалтын баг

Х.Очирбат

“Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны хэлтсийн менежер

Б.Төрцэцэг

“Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн захирал

Т.Цэвэлмаа

“Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер

Мэдээлэл цуглуулагчид:

Б.Ариунгэрэл (гэрээт судлаач)

Б.Номин (гэрээт судлаач)

Т.Болормаа (гэрээт судлаач)

Л.Дашзэвгэ (гэрээт судлаач)

Ц.Төрбат (гэрээт судлаач)

М.Үүрцайх (гэрээт судлаач)

Б.Дөлгөөннاران (гэрээт судлаач)

Ц.Нямжавдолгор (гэрээт судлаач)

Ө.Нямаа (гэрээт судлаач)

Х.Алимаа (гэрээт судлаач)


З.Учралтөгс (гэрээт судлаач)

П.Солонго (гэрээт судлаач)

Ж.Бадамхорол (гэрээт судлаач)

01

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- 
- 1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ
 - 1.2. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ
 - 1.3. ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ
 - 1.4. ТАЙЛАНД ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГУУД
 - 1.5. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН АРГА
 - 1.6. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ
 - 1.7. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН БОЛОВСРУУЛАЛТ

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт судалгааны ажлын үндэслэл, зорилго, зорилт, хамрах хүрээ, арга зүй, түүврийн дизайн, мэдээллийн чанарын баталгаажуулалт, дүн шинжилгээний арга зүй, судалгааны зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй танилцуулсан болно.

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, төрийн үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, аж ахуйн нэгжийн хандлагыг тандан судлахад энэхүү судалгааны зорилго оршино. Зорилгоо ханган ажиллахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж байгаа иргэдийн үйлчилгээний сэтгэл ханамжийг үнэлэх;
- Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж байгаа иргэдийн мэдээллийн хүртээмжийн сэтгэл ханамжийг үнэлэх;
- Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж байгаа иргэдийн байгууллагын орчин болон дэд бүтцийн хүртээмжийн сэтгэл ханамжийг үнэлэх;
- Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж байгаа иргэдийн хүний нөөцийн чадамжийн сэтгэл ханамжийг үнэлэх;
- Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж байгаа иргэдийн хүний нөөцийн чадамжийн сэтгэл ханамжийг үнэлэх;
- Судалгааны үр дүнг шинжилж, хэрэгжүүлж болохуйц зөвлөмжүүдийг боловсруулах;

1.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Гадаадын иргэн харьяатын газрын төвийн болон орон нутгийн бүсийн боомтын ажилчид болон гадаадын иргэн харьяатын байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийг хамруулан авч үзэв.

1.3 ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ

Бид дэвшүүлсэн зорилго, зорилтод хүрэхийн тулд Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлж буй иргэд, ААНБ-ууд болон тухайн байгууллагын ажилтан, алба хаагчдын төлөөллийг хамруулан, нийт 305 түүвэр судалгааг гүйцэтгэсэн.

Хүснэгт 1. Түүврийн хуваарилалт

№	Судалгаанд оролцогчдын төрөл, ангилал	Түүврийн тоо	Мэдээлэл цуглуулах арга	Арга зүй	
1	ГИХГ-аар үйлчлүүлэгч иргэн	Монгол улсад шинээр оршин суух зөвшөөрөл хүссэн болон авсан иргэн Оршин суух зөвшөөрлийн хугацаагаа сунгасан иргэн	52	CAPI /Computer Assisted Personal Interview/	Түүвэр судалгаа


Оршин суух зөвшөөрлөө бүртгэлээс хасуулсан иргэн					
2	ГИХГ-аар үйлчлүүлэгч ААНБ	Гадаадын иргэнийг уригч ААНБ	153	CATI /Computer Assisted Telephone Interview/	
3	ГИХГ-ын ажилтан албан хаагч	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчид	100	CATI /Computer Assisted Telephone Interview/	Түүвэр судалгаа
Нийт түүврийн хэмжээ: 305					

1.4 ТАЙЛАНД ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГУУД

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг 1-5 оноогоор үнэлүүлэх байдлаар асуулгын хуудсыг боловсруулсан.

- Бид үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг олон улсын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хэмжих гол үзүүлэлт болох СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ИНДЕКС - ээр хэмжиж үр дүнг боловсруулсан.
- Энэхүү шинжилгээнд тодорхой шатлал бүхий хэмжүүрийг ашигладаг бөгөөд анх Ринсис Лайкерт 1932 онд боловсруулан гаргасан ба өнөөг хүртэл олон улсад өргөн ашиглагдаж байна.
- Лайкертын хэмжүүр нь ихэвчлэн ажилчид болон хэрэглэгчдийн дунд хийгддэг судалгааны хүрээнд ашиглагдаж сэтгэлзүйг хэмжих үндсэн үзүүлэлт болдог.


Зураг 1. Сэтгэл ханамжийн индекс, түүний утга



1.5 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН АРГА

Тогтоосон түүврийн дагуу холбогдох иргэдийн төлөөллөөс мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэхдээ таблет дээр суурилсан мэдээлэл цуглуулах аргыг ашигласан.

Зураг 1. Мэдээлэл цуглуулах аргууд



1.6 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ

Мэдээлэл цуглуулах явцад талбарын болон алсын зайн нийлсэн 4 шатны хяналтыг хийж ажилласан.

Зураг 2. Мэдээлэл цуглуулалтын хяналтын үе шатууд



1.7 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Цуглуулсан дата, мэдээлэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийх үр дүнд үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан бичихэд дараах программ хангамжуудыг ашигласан. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах: **CS Pro 7.7, FREE PBX**
- Мэдээлэл боловсруулах: **SPSS Software 25.0**

- Тайлан боловсруулах: **MS-Office 2016**

Тоон судалгааны мэдээлэл боловсруулах: SPSS Software 25.0


Судалгааны мэдээлэл оруулах үе шатнаас эхлэн анхдагч засварлалт, ахисан шатны хяналтууд хийгдэж эхэлсэн. Мөн хугацаанаас эхэлж судалгааны үндсэн болон нэмэлт хүснэгтүүдийн алгоритм боловсруулах ажил эхэлж судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа дуусаж сүүлийн дата мэдээлэл ирэх үед боловсруулж дууссан. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ энэхүү судалгаанд зориулан боловсруулсан стандарт томъёолол болон үр дүнгийн хүснэгтийн загварыг ашигласан.

Тайлан боловсруулах: MS-Office 2016

Тайлан боловсруулах шатанд MS-Office 2016 программын Word, Excel, Powerpoint программ хангамжийг ашигласан.

02

ГИХГ-ААС ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ИРГЭД ААНБ-ЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ


- 
- 2.1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
 - 2.2. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ
 - 2.2.1 ГИХГ-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ БОЛОН ШААРДЛАГА
 - 2.2.2 МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ
 - 2.2.3 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧИН

БҮЛЭГ II. ГИХГ-ААС ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ИРГЭД ААНБ-ЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ

2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцон иргэдийг үйлчилгээ авсан төрлөөр нь ангилаад харвал 74.6% нь ААНБ-төлөөлж үйлчилгээ авсан бол үлдсэн 25.4% нь гадаадын иргэдийг төлөөлж үйлчилгээ авсан байна.

График 1. Үйлчлүүлэгчдийн төрөл



Энэхүү судалгаанд “Гадаадын иргэн, харьяатын газар”-аас үйлчилгээ авсан нийт 205 иргэн, ААНБ-ыг хамруулсан бөгөөд тухайн оролцогчдыг хүйсээр нь задлан харвал дийлэнх буюу 72.7% нь эмэгтэй үлдсэн 27.3%-ийг эрэгтэй оролцогчид бүрдүүлж байна. Насны бүтцээр нь харвал 30-39 насныхан хамгийн их хувийг буюу 38.5%-ийг, 60-с дээш насныхан хамгийн бага буюу 2.4%-ийг бүрдүүлж байна.

График 2. Судалгаанд оролцогчдын хүйс






График 3. Судалгаанд оролцогчдын насны бүтэц




Судалгаанд оролцогчдыг насны бүтцийг хүйсээр нь харвал адилхан бүтэцтэй байгаа бөгөөд 30-49 насныхан дийлэнх хувийг бүрдүүлж байна.

График 4. Судалгаанд оролцогчдын насны бүтэц, хүйсээр




Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал 74.6% нь хувийн байгууллагад ажилладаг иргэд байсан бол үлдсэн 25.4%-ийг бусад төрлийн хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна.

График 5. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал



Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлогын хувьд 38% нь 1,500,000-3,000,000 төгрөгийн орлоготой иргэд байсан бол 3.9% нь 1,000,000 хүртэл орлоготой иргэд байсан байна.

График 6. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого



Оршин суудаг байршлын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 91.2% Улаанбаатар хотод оршин суудаг бол үлдсэн 8.8% нь орон нутагт оршин суудаг байна.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын байршил, heat map





График 7. Судалгаанд оролцогчдын оршин суудаг байршил




2.2 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.2.1 ГИХГ-ын үйлчилгээний төрөл болон шаардлага

Судалгаанд оролцогчдыг авсан үйлчилгээний төрлөөр ангилаад харвал нийт оролцогчдын 92.2% нь виз зөвшөөрлийн үйлчилгээ, 24.9% нь зөрчил шалган шийдвэрлэх үйлчилгээ, 9.8% нь харьяатын чиглэлийн үйлчилгээг тус тус авсан байна.

График 8. Судалгаанд оролцогчдын авсан үйлчилгээний төрөл




Зураг 4. ГИХГ-ын үйлчилгээний төрлүүд




Үйлчлүүлэгчдийн төрлийг үйлчилгээний төрөлтэй нь харьцуулаад харвал ААНБ болон иргэдийн хувьд аль аль нь 86.5-с дээш хувь нь виз зөвшөөрөх чиглэлийн үйлчилгээг авсан бол ААНБ-ын 30.1%, иргэдийн 9.6% нь зөрчил шалган шийдвэрлэх үйлчилгээг авсан байна. Үүнээс үзэхэд ААНБ-ын хувьд зөрчил шалган шийдвэрлэх үйлчилгээг түгээмэл авах хандлагатай байдаг бол иргэдийн хувьд эсрэгээрээ харьяатын чиглэлийн үйлчилгээг ААНБ-с харьцангуй их авдаг байна.

График 9. Үйлчлүүлэгчдийн төрөл, авсан үйлчилгээний төрлөөр




Харьяатын, зөрчил шалган шийдвэрлэх, виз зөвшөөрөх гэх 3 чиглэлийг үйлчилгээ тус бүрээр нь хэрхэн авч байгааг харвал виз зөвшөөрөх чиглэлийн үйлчилгээ буюу МУ-ын визийн зөвшөөрөл олголт, МУ-д оршин суух зөвшөөрөл олголт, Оршин суух үнэмлэх визний сунгалт гэх үйлчилгээнүүдийг судалгаанд оролцогчдын 55-с дээш хувь нь тус тус авсан бол харьяатын чиглэлийн буюу МУ-ын харьяат болох, МУ-ын харьяатаас гарах МУ- иргэний харьяаллыг сэргээх гэсэн үйлчилгээ тус бүрийг судалгаанд оролцогчдын 3 хүрэхгүй хувь нь авсан байна.

График 10. ГИХГ-аас авсан үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь



ГИХГ-аас авсан үйлчилгээ бүрийг үйлчлүүлэгчдийн төрлөөр нь ангилаад харвал судалгаанд оролцсон иргэд МУ-ын харьяат болох болон харьяатаас гарах үйлчилгээг 100% буюу бүгд авсан бол зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээг ердөө 9.8% нь авсан байна. ААНБ-уудын хувьд зөрчил шалган шийдвэрлэх үйлчилгээг 90.2% нь авсан бол харьяатын чиглэлийн үйлчилгээг хамгийн бага хувьтай авсан байна.

График 11. ГИХГ-аас авсан үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь, үйлчлүүлэгчдийн төрлөөр




Гадаадын иргэн, харьяатын газраас үйлчилгээ авахад зарцуулж буй хугацааг харвал хамгийн их буюу 35.6% нь 1-с дээш өдрийг зарцуулдаг гэсэн бол 26.3% нь 1-3 цаг, 24.9% нь 1 цаг хүртэл, 7.8% нь 3-5 цаг, 5.4% нь 5-8 цаг гэсэн хариултыг тус тус илгээсэн байна.

График 12. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа



Гадаадын иргэн, харьяатын газраас үйлчилгээ авахад зарцуулж буй хугацааг үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал ААНБ-ууд нь илүү их хугацаа зарцуулж байгаа бөгөөд 41.2% нь 1-с дээш өдрийг зарцуулдаг гэж хариулсан байна.

График 13. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа, үйлчлүүлэгчдийн төрлөөр



Үйлчилгээ авахад зарцуулж буй хугацааг үйлчилгээ тус бүрээр нь харвал МУ-д албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, МУ-д үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын ТББ-ын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх төрлүүд нь хамгийн их хугацаа шаарддаг бөгөөд судалгаанд оролцогчдын 50-с дээш хувь энэхүү 2 үйлчилгээг авахад 1-с дээш өдөр зарцуулдаг хэмээн хариулсан байна. Харин МУ-ын харьяат болох болон МУ-ын иргэний харьяаллыг сэргээн тогтоох гэсэн үйлчилгээнүүдийг авахад хамгийн бага буюу судалгаанд оролцогчдын дийлэнх нь 1 цаг хүртэлх хугацааг зарцуулдаг гэж хариулсан байна.


Хүснэгт 2. ГИХГ-с үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа, үйлчилгээний төрлөөр

№	Үйлчилгээний төрөл	1 цаг хүртэлх	1-3 цаг	3-5 цаг	5-8 цаг	1-с дээш өдөр
1	Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт	23.8%	28.7%	8.4%	5.6%	33.6%

2	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олголт	25.0%	23.3%	8.6%	6.0%	37.1%
3	Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн	26.7%	16.7%	3.3%	3.3%	50.0%
4	Оршин суух үнэмлэх, визний сунгалт	28.1%	20.2%	9.6%	4.4%	37.7%
5	Монгол Улсын харьяат болох	50.0%	50.0%	-	-	-
6	Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох	40.0%	40.0%	20.0%	-	-
7	Монгол Улсын иргэний харьяатаас гарах	-	100.0%	-	-	-
8	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын ТББ-ын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх	30.0%	-	10.0%	-	60.0%
9	Гадаадын иргэний хяналт шалгалтын үйл ажиллагаа	27.5%	29.4%	11.8%	3.9%	27.5%


Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материалын хувьд судалгаанд оролцогчдын 37% нь 4-6, 29% нь 7-9, 24% нь 10-с дээш, 10% нь 3 хүртэл гэсэн хариултыг тус тус илгээсэн байна.

График 14. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал




Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материалын тоог үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал ААНБ-ын 26.1% нь 10-с дээш материал бүрдүүлдэг гэж хариулсан бол судалгаанд оролцсон иргэдийн 23.1% нь 3 хүртэл баримт бүрдүүлдэг гэж хариулт илгээсэн байна.

График 15. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал, үйлчлүүлэгчдийн төрлөөр




Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материалыг үйлчилгээний төрлөөр нь харьцуулаад харвал харьяатын чиглэлийн үйлчилгээнүүдийг авахад бүрдүүлдэг материалын тоо бусдаасаа бага зэргийн илүү байна.

График 16. Үйлчилгээ авахын тулд бүрдүүлж буй материал, үйлчилгээ тус бүрээр харвал



Судалгаанд оролцогчдын хувьд дээрх материалуудыг 64.9% нь өөр газраас бүрдүүлсэн бол 33.2% нь нэг дороос гэсэн хариултыг илгээсэн байна.

График 17. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх




Мөн судалгаанд оролцогчдын 2% нь бусад гэсэн хариулт илгээсэн бөгөөд дараах хариултауд ирсэн байна.

- Дүүрэг хорооноос, оршин суугаа хаягийн тодорхойлолт авдаг,
- Нэгдсэн тодорхой мэдээлэлд хавсаргах материал зэрэг тодорхой чиглэлгүй тул цаг алдах зэрэг бас яаралтай болон энгийн төлбөрийн ялгаа алга,
- Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтуудыг цахимаар авч бүрдүүлж явуулсан.


Бүрдүүлж буй материалын хувьд судалгаанд оролцогчдын төрлөөс үл хамааран дийлэнх тохиолдолд өөр өөр газраас бүрдүүлэлт хийдэг байна.

График 18. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх, үйлчлүүлэгчдийн төрлөөр




Материал бүрдүүлэлтийг үйлчилгээний төрлөөр харвал үйлчилгээнээс үл хамааран өөр газраас бүрдүүлэх тохиолдол давамгайлж байна.

График 19. Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн эсэх, үйлчилгээний төрлөөр




Судалгаанд оролцогчдоос үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаг эсэхийг тодруулахад 64.4% нь үгүй гэж хариулсан бол үлдсэн 35.6% нь ямар нэгэн хүндрэл гардаг гэж хариулсан байна.

График 20. ГИХГ-с үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл гарсан эсэх



Хүндрэл гардаг хэмээн хариулсан судалгаанд оролцогчдоос тодруулж асуухад хамгийн их буюу 16.6% нь хариу өгөх байдал удаашралтай гэж хариулсан бол 13.7% нь зөвлөгөө мэдээлэл авахад хугацаа их шаарддаг, 10.2% нь бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт ойлгомжгүй, 7.3% нь баримт бичиг хаанаас бүрдүүлэх нь тодорхойгүй, 6.3% нь хариуцсан мэргэжилтний ур чадвар дутмаг гэж тус тус хариулсан байна.

График 21. Үйлчилгээ авахад гарсан хүндрэл




Мөн судалгаанд оролцогчдын 19.5% нь бусад гэсэн хариулт илгээсэн бөгөөд дараах хариултууд ирсэн байна.

- 18001882 утсаар холбогдоход их хүндрэлтэй удаашралтай байсан
- Isf.mn системтэй ажиллах маш их цаг авдаг, file татаж авахдаа зургийн чанар маш их буурдгаас болоод их асуудал гардаг
- Бүрдүүлэх материал их Хөдөлмөр халамжаас заавал бичиг авах гэх мэт) тэрнээс болоод удаашралтай
- Гадаадын иргэн нэвтрэх мэдээллийг 10-с дээш удаа залгаж байж менежертэй утсаар ярьж байж мэдэж авсан. Бусад мэдээллийн ажилчид энэ талаар мэдлэггүй заавар өгөөгүйн улмаас хугацаа алдсан
- Жагсаалтад байхгүй материал нэмэлтээр нэхдэг хугацаа тулсан байхад
- Утсаа авдаггүй олон бичиг баримт бүрдүүлж яаралтайгаар төлбөрөө төлж байхад ажлын бус цагаар хариу ирдэг удаашралтай ямар шалтгаанаар буцаасан нь тодорхой ч тэр нь хүндрэл дандаа учруулдаг нэмэлт юм шаарддаг.


Үйлчилгээ авахад гарсан хүндрэл бэрхшээлийг үйлчилгээний төрлөөр харвал харьяатын чиглэлийн үйлчилгээг авахад бүрдүүлэх баримтын жагсаалт болон хаанаас бүрдүүлэх нь тодорхойгүй хариу өгөх байдал удаашралтай гэх мэт асуудлууд хамгийн их тулгамддаг байна. Харин виз зөвшөөрөх чиглэлийн үйлчилгээг авахад хариу өгөх байдал удаашралтай, зөвлөгөө мэдээлэл авахад хугацаа их шаарддаг гэх асуудлууд хамгийн түгээмэл тулгардаг бол зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээ авахад хариу өгөх байдал удаашралтай бүрдүүлэх баримтын жагсаалт ойлгомжгүй гэх асуудлууд хамгийн түгээмэл тулгамддаг байна. Үүнээс үзэхэд үйлчилгээний чиглэлээс үл хамааран хариу өгөх байдал болон бүрдүүлэх баримт бичгийн мэдээлэл дутмаг байдал нь маш их хүндрэл учруулдаг байна.

График 22. Үйлчилгээ авахад гарсан хүндрэл, үйлчилгээний төрлөөр




Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний чанарыг үнэлүүлэхэд үйлчилгээний түргэн шуурхай байдал болон материал бүрдүүлэхэд ойлгомжтой байдал гэх 2 үзүүлэлт нь хамгийн өндөр буюу 3.9 оноотой байгаа боловч сайн гэсэн үзүүлэлтэд хараахан хүрэхгүй байгаа юм. Харин хамгийн бага оноотой байгаа үзүүлэлт нь санал гомдол илэрхийлэх боломжтой байдал гэсэн үзүүлэлт байсан бөгөөд 3.5 буюу дундаж гэсэн үзүүлэлттэй байна.

График 23. Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ




Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний үнэлгээг үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал иргэдийн хувьд үйлчилгээний ажилчид асуудлыг нэг удаагийн шийдвэрлэж өгөх байдал болон мэдээллийн хангалттай байдал гэх үзүүлэлтүүд нь сайн буюу 4 оноотой байгаа бол үйлчилгээний талаар хариу мэдээлдэг байдал нь хамгийн бага оноотой байна. ААНБ-ын хувьд үйлчилгээний түргэн шуурхай байдал нь сайн луу дөхсөн буюу 3.92 оноотой байгаа бол санал гомдлын дагуу арга хэмжээ авдаг байдал нь дундаж буюу 3.49 оноотой байна.

График 24. Виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр




Харьяатын чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээний хувьд ажилтны тоо хүрэлцээтэй байдал болон ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал гэх мэт үзүүлэлтүүд нь сайн луу хамгийн ойртсон оноотой байгаа бол санал гомдол илэрхийлэх боломжтой байдал нь хамгийн бага буюу 3.2 оноотой байна.

График 25. Харьяатын чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ




Харьяатын чиглэлийн үйлчилгээний үйлчилгээг үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал ААНБ-уудад санал гомдол илэрхийлэх боломжтой байдал хамгийн сул санагдсан буюу хамгийн бага оноотой байгаа бол иргэдийн хувьд үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал хамгийн бага буюу 3.2 оноотой байна.

График 26. Харьяатын чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр




Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний үнэлгээний хувьд бүх үзүүлэлт нь дундаж гэсэн үнэлгээтэй байгаа бол сайн луу хамгийн ойртсон үнэлгээтэй байгаа үзүүлэлт нь ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал гэсэн үзүүлэлт байна.

График 27. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ



Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний үзүүлэлтүүдийн үнэлгээг үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал иргэдийн хувьд ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал болон санал гомдлын дагуу арга хэмжээ авдаг байдал нь сайн буюу 4 оноогоор үнэлэгдсэн бол ААНБ-уудын хувьд бүх үзүүлэлт дундаж гэсэн үнэлгээтэй байна.


График 28. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний чанарын үнэлгээ, үйлчлүүлэгчийн төрлөөр



Цахим үйлчилгээний чанарын үнэлгээг үзүүлэлт тус бүрээр харвал сайн буюу 4 оноо руу дөхсөн үзүүлэлтүүд нь ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал, үйлчилгээний талаар хариу мэдээлдэг байдал, веб хуудсан дах үйлчилгээний талаарх

мэдээллийн хангалттай байдал гэх үзүүлэлтүүд байсан бол санал гомдол илэрхийлэх боломжтой байдал гэсэн үзүүлэлт нь хамгийн бага **3.61** оноогоор үнэлэгдсэн байна.

График 29. Цахим үйлчилгээний чанарын үнэлгээ



Цахим үйлчилгээг авахад гардаг хүндрэл бэрхшээлийг тодруулахад 36.1% нь асуудал тулгардаггүй гэж хариулсан байна. Харин асуудлын хувьд систем гацдаг алдаа заах асуудал 8.3%, хэт их асуулт бөглүүлдэг 7.3%, хугацааны хувьд хүндрэлтэй удаан хүлээлгэдэг 5.9%, баримт бичигтэй холбоотой асуудал 5.9%-ийг тус тус бүрдүүлж байна.

График 30. Цахим үйлчилгээ авахад гардаг хүндрэл бэрхшээл




Мөн судалгаанд оролцогчдын 15.8% нь бусад гэсэн хариулт илгээсэн бөгөөд дараах хариултууд ирсэн байна.

- Өмнө оруулсан мэдээллийг Isf.mn дээр дахин оруулах шаардлага гардаг
- Визний ангиллын ойлгомжгүй байдал
- Тоон гарын үсэг ашиглах нь хүндрэлтэй
- Мэдээлэл авахад хүндрэлтэй, ойлгомжгүй
- Төрийн байгууллагын зарим бичиг баримт цахимаар хавсаргах
- Журам байнга өөрчлөгддөг, мэдээлэл өгдөггүй


Судалгаанд оролцогчдоос хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэхийг тодруулахад 79% нь бүрэн авч чадсан гэж хариулсан бол 3.9% нь хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй гэж хариулсан байна.

График 31. Хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэх



Үйлчилгээ авсан иргэдийн 9.6% нь хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй бол ААНБ-ын 2% нь хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй гэсэн хариултыг илгээсэн байна.


График 32. График 33. Хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэх, үйлчлүүлэгчдийн төрлөөр



ГИХГ-аас үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах саналыг нийт судалгаанд оролцогчдоос тодруулахад 26.8% нь санал хүсэлт байхгүй гэж хариулсан бол цахим

үйлчилгээг хялбар болгож хөгжүүлэх, түргэн шуурхай үйлчлэх, сургалт зохион байгуулах, визийн үйлчилгээг сайжруулах гэх саналууд хамгийн их ирсэн байна.

График 34. Үйлчилгээг сайжруулахад шаардлагатай ажлын санал



Хүснэгт 3. Үйлчилгээг сайжруулахад шаардлагатай ажлын санал, үйлчилгээний төрлөөр


Санал хүсэлт	Виз зөвшөөрөх чиглэл	Харьяатын чиглэл	Зөрчил шалган шийдвэрлэх
Санал, хүсэлт байхгүй	28.0%	20.0%	19.6%
Түргэн шуурхай үйлчлэх	9.0%	5.0%	9.8%
Эргээд хариу мэдээлэл өгөхөд сайн анхаарах	1.6%	-	2.0%
Дуудлагын төвийн үйл ажиллагааг сайжруулах	4.2%	-	3.9%
Цахим үйлчилгээг илүү хялбар болгох, хөгжүүлэх	14.8%	20.0%	19.6%
Үйлчилгээг хотын төвд ойртуулах	1.6%	-	3.9%
Бүх үйлчилгээгээ цахимжуулах, нэг дороос авах	3.7%	-	9.8%
Сургалт зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх	4.8%	5.0%	2.0%
Ажилчдын харилцаа, хандлагыг сайжруулах	3.2%	10.0%	9.8%
Паспортын мэдээлэл, зураг танилтыг сайжруулах	2.1%	5.0%	-
Ажилчдын ойлголтыг нэг болгох	2.6%	5.0%	-
Ажилчдын тоог нэмэх	1.1%	15.0%	3.9%
Ажлын цагийг уртасгах	-	-	2.0%
Визийн үйлчилгээг сайжруулах	4.2%	-	3.9%
Баримт бичгийн мэдээлэл, жагсаалтыг тодорхой болгох	2.6%	-	3.9%
Яаралтай үйлчилгээг хурдан болгох	0.5%	-	-
Цахимаар мэдээлэл өгөх	2.6%	5.0%	-
Оршин суух зөвшөөрлийн үйлчилгээг сайжруулах	2.6%	-	-

Хэт олон зүйл асуухгүй байх	3.7%	-	2.0%
Үйлчилгээ тодорхой, ойлгомжтой байх	0.5%	-	-
Бусад	3.2%	5.0%	2.0%
Мэдэхгүй	3.2%	5.0%	2.0%

2.2.2 Мэдээллийн хүртээмжтэй байдал


Судалгаанд оролцогчдын ГИХГ-ын талаарх мэдлэгийг үнэлэхэд 47.3% нь сайн гэж хариулсан бол 5.9% нь муу гэж хариулсан байна.

График 35. Судалгаанд оролцогчдын ГИХГ-ын талаарх мэдлэг



ГИХГ-ын талаарх мэдлэгийг судалгаанд оролцогчдын төрлөөр харвал байгууллагын үйлчлүүлэгчид илүү их мэдээлэлтэй байдаг бөгөөд 54.2% нь өөрсдийн мэдлэгийг сайн гэж үнэлжээ.

График 36. ГИХГ-ын талаарх мэдлэг, үйлчлүүлэгчдийн төрлөөр




Мэдээллийн хүртээмжтэй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг судалгаанд оролцогчдоор үнэлүүлэхэд байгууллагын веб хуудсан дах мэдээллийн хүртээмж хамгийн өндөр буюу 3.9 оноотой байгаа бол зөвлөгөө мэдээллийн 1800-1882 утасны хүртээмж хамгийн бага буюу 3.3 оноотой дундаж гэсэн үнэлгээтэй гарсан байна.

График 37. Мэдээллийн хүртээмжтэй байдал




Мэдээллийн хүртээмжтэй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээг үйлчлүүлэгчдийн төрлөөр харвал байгууллагын үйлчлүүлэгчдэд илүү хүртээмжтэй санагддаг бөгөөд үзүүлэлт тус бүр дээр иргэдээс илүү өндөр оноо өгсөн байна.

График 38. Мэдээллийн хүртээмжтэй байдал, үйлчлүүлэгчдийн төрлөөр



Мэдээллийг өөр ямар нэмэлт эх сурвалжаар түгээвэл тохиромжтой байхыг тодруулахад 25.9% нь хангалттай түвшинд байгаа гэж үзсэн бол 12.7% нь бүх социал хуудсаар мэдээлэл өгөх, 8.3% нь ГИХГ-ын веб сайтай илүү ойлгомжтой болгох, 5.4% нь лавлах утсаар мэдээлэл өгөх гэсэн хариултуудыг илгээсэн байна.

График 39. Мэдээллийг ямар нэмэлт эх сурвалжаар авмаар байгаа санал




Үйлчилгээний хүртээмжтэй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг харвал үйлчилгээг хэрхэн авах нь энгийн ойлгомжтой байх байдал хамгийн өндөр буюу 3.84 оноотой байгаа бол үйлчилгээний ачааллын хэвийн байдал нь хамгийн бага буюу 3.68 оноотой дундаж гэж үнэлэгдсэн байна.

График 40. Үйлчилгээний хүртээмжтэй байдал




Үйлчилгээний хүртээмжтэй байдлыг үйлчилгээний төрлөөр харвал харьяатын чиглэлийн үйлчилгээний хүртээмж харьцангуй бага буюу хамгийн бага оноотой байгаа бол виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний үнэлгээ бусдаасаа илүү өндөр оноотой байна.

График 41. Үйлчилгээний хүртээмжтэй байдал, үйлчилгээний төрлөөр




Албан хаагчдын ёс зүйн үнэлгээний дундаж нь 3.87 буюу дундаж гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд үүнд хамаарах үзүүлэлтүүдээс хамгийн өндөр оноотой нь мэргэжилтнүүдийн хариуцлагатай шударга байдал гэх үзүүлэлт байсан байна.

График 42. Албан хаагчдын ёс зүйн үнэлгээ



Албан хаагчдыг ёс зүйн үнэлгээг үйлчилгээний төрлөөр харвал виз зөвшөөрөх чиглэлийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүй хамгийн өндөр оноотой байсан бол харьяатын чиглэлийн үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын дундаж оноо хамгийн бага оноотой байна.


График 43. Албан хаагчдын ёс зүйн үнэлгээ, үйлчилгээний төрлөөр



2.2.3 Байгууллагын үйлчилгээний орчин


Үйлчилгээний орчны хувьд нийт судалгаанд оролцогчдын дундаж үнэлгээ нь 3.85 оноотой байна. Үйлчилгээний орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн хувьд цэвэрлэгээ үйлчилгээ 4.12 буюу сайн гэсэн үнэлгээтэй байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчны үнэлгээ 3.54 буюу хамгийн бага оноотой үнэлэгдсэн байна.

График 44. Үйлчилгээний орчны үнэлгээ



Зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааны үнэлгээг харвал иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хариу өгөх арга хэмжээ авах гэсэн үзүүлэлт нь 3.8 буюу сайн луу дөхсөн оноотой байгаа бол хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл сургалт, сурталчилгааны зохион байгуулалт гэсэн үзүүлэлт нь 3.6 буюу дундаж гэсэн үнэлгээтэй байна.

График 45. Зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааны үнэлгээ



03

АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ

3.1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

3.2. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ

3.2.1. АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН АЧААЛАЛ

3.2.2 АЛБАН ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАЛ

3.2.3 ДЭЭД АЛБАН ТУШААЛТНЫ УР ЧАДВАР,
ХАНДЛАГА


3.2.4 БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ III. АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭСЭГ

3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Судалгаанд оролцсон албан хаагчдыг албан тушаалын түвшнээр нь харвал дийлэнх буюу 59% нь гүйцэтгэх албан тушаалтан бол үйлчилгээний албан хаагчид 21%, дунд шатны албан хаагчид 12%, удирдах албан тушаалтан 7%, туслах ажилтан 1%-ийг тус тус эзэлж байна.

График 46. Судалгаанд оролцогчдын албан тушаал



Судалгаанд оролцсон албан хаагчдыг ажиллаж буй байршлаар нь харвал дийлэнх буюу 58%-ийг Улаанбаатар хотод ажиллаж буй албан хаагчид эзэлж байгаа бол үлдсэн хувийг нь орон нутагт ажиллаж буй албан хаагчид бүрдүүлж байна.

График 47. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй байршил



Албан хаагчдыг хүйсээр нь харвал харьцангуй тэгш буюу 53%-ийг эмэгтэйчүүд, 47%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Судалгаанд оролцсон албан хаагчдыг насны ангиллаар нь хараад үзвэл 30-49 насныхан дийлэнх хувийг бүрдүүлж байна. Албан хаагчдыг хүйсээр нь харвал харьцангуй тэгш буюу 53%-ийг эмэгтэйчүүд, 47%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Судалгаанд оролцсон албан хаагчдыг насны ангиллаар нь хараад үзвэл 30-49 насныхан дийлэнх хувийг бүрдүүлж байна.

График 48. Судалгаанд оролцогчдын хүйс






График 49. Судалгаанд оролцогчдын нас




Судалгаанд оролцсон албан хаагчдыг боловсролын түвшнээр нь ангилаад харвал хамгийн их буюу 64%-ийг бакалавр түвшний боловсролтой албан хаагчид эзэлж байгаа бол хамгийн бага буюу 1%-ийг бага боловсролтой албан хаагчид бүрдүүлж байна.

График 50. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин




Сарын дундаж орлогын хувьд дийлэнх буюу 68%-ийг 1,500,000-3,000,000 төгрөгийн орлоготой албан хаагчид эзэлж байгаа бол хамгийн бага буюу 2% нь 1,000,000 хүртэл орлоготой албан хаагчид байна.

График 51. Судалгаанд оролцогчдын сарын дундаж орлого



Албан хаагчдын тухайн байгууллагад ажиллаж буй хугацаагаар нь харвал 30% нь 10-с дээш жил, 25% нь 5-10 жил, 18% нь 3-5 жил, 14% нь 1-3 жил, 13% нь 1 жил хүртэл ажиллаж байгаа албан хаагчид судалгаанд хамрагдсан байна. Үүнээс үзэхэд судалгаанд оролцсон дийлэнх оролцогчид нь урт хугацаанд ажиллаж байгаа албан хаагчид байна.

График 52. Судалгаанд оролцогчдын тус байгууллагад ажиллаж буй хугацаа



3.2 СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүдийн хувилбаруудыг эзлэх хувиар нь харвал судалгаанд оролцогчдын дийлэнх нь 3-5 оноо өгсөн бөгөөд ажлын сэтгэл ханамж болон дээд албан тушаалтны ур чадвар нь маш сайн гэсэн үнэлгээг хамгийн их авсан байна.

Хүснэгт 4. Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их	Мэдэхгүй
Ажлын ачаалал	6.0%	10.0%	34.0%	33.0%	17.0%	-
Ажилдаа хэр сэтгэл ханамжтай байдал	-	1.0%	10.0%	46.0%	43.0%	-
Дээд албан тушаалтны харилцаа хандлага	-	2.0%	19.0%	41.0%	38.0%	-
Дээд албан тушаалтны ур чадвар	-	2.0%	11.0%	47.0%	37.0%	3.0%
Байгууллагын дотоод уур амьсгал	2.0%	4.0%	25.0%	39.0%	30.0%	-
Байгууллагын орчин	3.0%	5.0%	22.0%	41.0%	29.0%	-

Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүдийг харахад ажлын сэтгэл ханамж болон дээд албан тушаалтны ур чадвар хамгийн өндөр оноотой байгаа бол ажлын ачаалал хамгийн бага оноог авсан байна.


График 53. Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүдийн дундаж оноо



3.2.1 Албан хаагчдын ажлын ачаалал

Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас ажлын ачааллыг үнэлүүлэхэд 34% нь дунд, 33% нь их 17% нь маш их, 10% нь баг гэж тус тус хариулсан бөгөөд дундаж оноог харвал **3.5** буюу дундаж ачаалалтай гэж үнэлэгдсэн байна.

График 54. Ажлын ачааллын үнэлгээ




Ажлын ачааллыг ажиллаж буй байршлаар нь харвал Баян-Өлгий болон Дархан-Уул аймгуудад ажлын ачаалал хамгийн бага байгаа бөгөөд **4** оноогоор үнэлэгдсэн бол бусад байршлуудад ажиллаж буй албан хаагчдын хувьд дундаж ачаалалтай гэж үнэлэгдсэн байна.

График 55. Ажлын ачааллын үнэлгээ, ажиллаж буй байршлаар



Ажлын ачааллыг албан тушаалаар нь харвал удирдах болон туслах албан тушаалтай албан хаагчдын ажлын ачаалал хамгийн бага байгаа бол дунд шатны албан тушаалтнуудын ажлын ачаалал харьцангуй их буюу **3.2** оноогоор үнэлэгдсэн байна.


График 56. Ажлын ачааллын үнэлгээ, эрхэлж буй албан тушаалаар



3.2.2 Албан хаагчдын сэтгэл ханамжтай байдал


Судалгаанд оролцсон албан хаагчдын хувьд ажилдаа маш өндөр сэтгэл ханамжтай байдаг бөгөөд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ нь **4.3** оноогоор үнэлэгдсэн байна.

График 57. Сэтгэл ханамжтай байдал




Сэтгэл ханамжтай байдлыг албан хаагчдын албан тушаалаар нь ангилаад харвал туслах ажилтнууд хамгийн өндөр сэтгэл ханамжтай байдаг бөгөөд **5** оноогоор үнэлсэн бол бусад албан түвшний ажилтнууд бүгд **4**-с дээш оноогоор үнэлсэн байна.

График 58. Сэтгэл ханамжтай байдал, эрхэлж буй албан тушаалаар



Сэтгэл ханамжтай байдлыг албан хаагчдын ажиллаж буй байршлаар нь харвал орон нутгийн дундаж оноо маш сайн руу дөхсөн оноотой байгаа бол Улаанбаатар хотын албан хаагчид сайн гэсэн үзүүлэлттэй байна.


График 59. Сэтгэл ханамжтай байдал, ажиллаж буй байршлаар



3.2.3 Дээд албан тушаалтны харилцаа хандлага болон ур чадвар


Дээд албан тушаалтны харилцаа хандлагыг тухайн байгууллагын албан хаагчид дунджаар 4.2 оноогоор буюу сайн гэж үнэлсэн бөгөөд ердөө 2% нь харилцаа хандлага муу гэсэн хариултыг илгээсэн байна.

График 60. Дээд албан тушаалтны харилцаа хандлагын үнэлгээ




Дээд албан тушаалтны харилцаа хандлагыг судалгаанд оролцсон албан хаагчдын албан тушаалаар нь ангилаад харвал туслах ажилтнуудын хувьд маш сайн буюу 5 оноотой байгаа бол үйлчилгээний албан хаагчдын хувьд 3.8 оноотой буюу сайн руу дөхсөн үзүүлэлттэй байна.

График 61. Дээд албан тушаалтны харилцаа хандлага, эрхэлж буй албан тушаалаар




Дээд албан тушаалтны харилцаа хандлагыг судалгаанд оролцсон албан хаагчдын ажиллаж буй байршлаар нь ангилаад харвал Улаанбаатар хотын албан хаагчдын үзүүлэлт хангалтгүй буюу **3.9** оноотой байгаа бол орон нутгийн албан хаагчдын **4.5** буюу маш сайн руу дөхсөн үзүүлэлттэй байна.

График 62. Дээд албан тушаалтны харилцаа хандлага, ажиллаж буй байршлаар




Дээд албан тушаалтны ур чадварыг судалгаанд оролцсон албан хаагчдын 47% нь сайн, 37% нь маш сайн, 11% дунд, 3% нь мэдэхгүй гэж тус тус хариулсан бөгөөд дунджаар **4.2** буюу сайн гэсэн үнэлгээтэй гарсан байна.

График 63. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ



Дээд албан тушаалтны ур чадварыг албан хаагчдын ажиллаж буй түвшнээр нь харвал бүгд **4** онооноос дээш буюу сайн гэж үнэлсэн бөгөөд туслах албан хаагчид **5** оноо буюу маш сайн гэж үнэлсэн байна.

График 64. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ, эрхэлж буй албан тушаалаар



Дээд албан тушаалтны ур чадварыг үнэлсэн албан хаагчдын ажиллаж буй байршилтай нь харьцуулаад харвал орон нутгийн албан хаагчдын үнэлгээ Улаанбаатар хотын албан хаагчдаас өндөр үзүүлэлттэй байна.


График 65. Дээд албан тушаалтны ур чадварын үнэлгээ, ажиллаж буй байршлаар



3.2.4 Байгууллагын дотоод орчны үнэлгээ


Байгууллагын дотоод уур амьсгалын хувьд албан хаагчдын 39% нь сайн, 30% нь маш сайн, 25% нь дунд, 4% нь муу, 2% нь маш муу гэж үнэлсэн бөгөөд дундаж оноо нь **3.9** сайн гэсэн үнэлгээтэй байна.

График 66. Байгууллагын дотоод уур амьсгал



Байгууллагын дотоод уур амьсгалын үнэлгээг албан хаагчдын ажиллаж буй түвшнээр нь харвал туслах ажилтнуудын хувьд маш сайн буюу **5** оноогоор үнэлсэн бол үйлчилгээний албан хаагчид **3.8** оноогоор үнэлсэн байна.

График 67. Байгууллагын дотоод уур амьсгал, эрхэлж буй албан тушаалаар




Байгууллагын дотоод уур амьсгалыг үнэлсэн албан хаагчдын ажиллаж буй байршилтай нь харьцуулаад харвал

График 68. Байгууллагын дотоод уур амьсгал, ажиллаж буй байршлаар




Байгууллагын дотоод орчны хувьд албан хаагчдын 41% нь сайн, 29% нь маш сайн, 22% нь дунд, 5% нь муу, 3% нь маш муу гэж үнэлсэн байна.

График 69. Байгууллагын дотоод орчин




Байгууллагын дотоод орчныг үнэлсэн албан хаагчдын ажиллаж буй байршилтай нь харьцуулаад харвал орон нутгийн албан хаагчдын хувьд сайн гэсэн үзүүлэлттэй байгаа бол Улаанбаатар хотын албан хаагчдын хувьд хангалтгүй үзүүлэлттэй байна.

График 70. Байгууллагын дотоод орчин, ажиллаж буй байршлаар




Байгууллагын дотоод орчны үнэлгээг албан хаагчдын ажиллаж буй түвшнээр нь харвал туслах ажилтнуудын хувьд маш сайн буюу 5 оноогоор үнэлсэн бол үйлчилгээний албан хаагчид 3.5 оноогоор үнэлсэн байна.

График 71. Байгууллагын дотоод орчин, эрхэлж буй албан тушаалаар



Байгууллагын дотоод орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг харвал ширээ сандал, гэрэлтүүлэг, компьютер тоног төхөөрөмж гэсэн үзүүлэлтүүд нь 4-с дээш буюу сайн гэсэн үнэлгээтэй байгаа бол гал тогоо, чөлөөт цагаа өнгөрөөх боломж гэсэн үзүүлэлтүүд нь 3 буюу дундаж гэсэн үзүүлэлттэй байна.

График 72. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн дундаж үнэлгээ



Байгууллагын дотоод орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг үнэлгээ өгсөн албан хаагчдын албан тушаалаар ангилаад харвал туслах ажилтнуудын хувьд гал тогоо

маш муу гэж үнэлсэн бол бусад үзүүлэлтүүдийг маш сайн гэж үнэлсэн байна. Удирдах албан тушаалтнуудын хувьд ширээ сандал, компьютер тоног төхөөрөмжийг сайн гэж үнэлсэн бол чөлөөт цагаа өнгөрөөх боломж болон гал тогоо гэсэн үзүүлэлтийг муу гэж үнэлсэн байна. Мөн доорх хүснэгтээс харахад албан тушаалаас үл хамааран чөлөөт цагаа өнгөрөөх боломж хомс байдаг бөгөөд энэхүү үзүүлэлтийн оноо нь хамгийн бага оноотой байна.

Хүснэгт 5. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн үнэлгээ, ажилчдын албан тушаалаар

Хүчин зүйлс	Удирдах албан тушаалтан	Дунд шатны албан тушаалтан	Гүйцэтгэх албан тушаалтан	Үйлчилгээний албан хаагч	Туслах
Ширээ сандал	4.4	3.9	4.3	4.3	5.0
Компьютер, тоног төхөөрөмж	4.6	3.7	4.0	4.2	3.0
Агааржуулалт	3.7	3.3	3.6	3.6	5.0
Цэвэрлэгээ, үйлчилгээ	3.9	3.4	3.9	4.1	5.0
Машины зогсоолын хүртээмж	2.9	4.0	4.0	4.1	3.0
Чөлөөт цаг өнгөрөөх боломж	2.7	3.1	2.8	3.3	5.0
Гэрэлтүүлэг	3.9	4.0	4.0	4.2	5.0
00-н хүрэлцээ	3.9	3.5	3.6	4.1	5.0
Гал тогоо	2.6	3.5	3.2	3.0	1.0

Байгууллагын дотоод орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг албан хаагчдын ажиллаж буй байршлаар нь харвал орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын хувьд гал тогоо болон чөлөөт цагаа өнгөрөөх боломж хомс бөгөөд хамгийн бага оноотой байгаа бол ширээ сандал болон компьютер тоног төхөөрөмж хамгийн өндөр оноотой байна.

Хүснэгт 6. Байгууллагын дотоод орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн үнэлгээ, ажиллаж буй байршлаар

Хүчин зүйлс	Улаанбаатар	Баян-Өлгий	Говь-Алтай	Дархан-Уул	Дорнод	Дорноговь	Завхан	Өмнөговь	Сэлэнгэ	Увс	Ховд
Ширээ сандал	4.3	4.5	3.5	4.0	3.7	4.8	5.0	5.0	4.4	3.8	4.1
Компьютер, тоног төхөөрөмж	4.1	4.8	3.0	4.0	4.4	3.8	5.0	4.3	4.0	2.8	3.9
Агааржуулалт	3.6	3.5	4.0	5.0	3.1	4.6	4.0	3.7	3.9	2.0	3.8
Цэвэрлэгээ, үйлчилгээ	3.9	4.8	4.5	4.0	3.4	4.8	4.0	2.3	4.1	2.8	4.4
Машины зогсоолын хүртээмж	4.1	2.0	4.0	3.0	4.0	4.2	2.0	5.0	3.4	3.5	4.5
Чөлөөт цаг өнгөрөөх боломж	3.0	2.8	4.5	3.0	3.0	4.3	1.0	2.0	3.6	2.3	2.5
Гэрэлтүүлэг	3.9	4.0	4.5	4.0	3.9	5.0	5.0	5.0	4.4	4.3	4.1
00-н хүрэлцээ	3.8	2.8	4.5	3.0	2.7	4.8	4.0	3.0	4.4	2.5	4.1
Гал тогоо	3.1	1.8	3.0	4.0	3.6	3.0	1.0	3.7	3.7	1.3	3.5

Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулахад дийлэнх буюу 48% нь хүндрэл бэрхшээл байхгүй гэж хариулсан бол 9% нь

хотын төвөөс хол, 8% нь орон сууцны хангамж муу, 5% нь ажилчдын харилцаа хандлага муу, 4% нь өрөө тасалгааны халаалт муу гэх мэт хариултуудыг тус тус илгээсэн байна.

Бусад гэсэн хариултыг 12% нь илгээсэн бөгөөд амрах өрөө байхгүй, гал тогоо байхгүй, тоног төхөөрөмжийг сайжруулах гэх мэт хариултуудыг илгээсэн байна.

График 73. Хүндрэл бэрхшээл



Тулгарч буй хүндрэл бэрхшээлийг албан хаагчдын албан тушаалаар нь ангилгаад харвал удирдах албан тушаалтай хүмүүсийн хувьд хүний нөөц болон ажиллах орчин хамгийн их тулгамдаж байгаа бол гүйцэтгэх болон үйлчилгээний албан хаагчдын хувьд дийлэнх хүндрэл бэрхшээл байхгүй гэж үзсэн бөгөөд хангамж нэмэгдүүлэх, хотын төвөөс хол гэх мэт асуудлуудыг мөн дэвшүүлсэн байна.

Хүснэгт 7. Хүндрэл бэрхшээл, эрхэлж буй албан тушаалаар

Хүндрэл бэрхшээл	Удирдах албан тушаалтан	Дунд шатны албан тушаалтан	Гүйцэтгэх албан тушаалтан	Үйлчилгээний албан хаагч	Туслах
Хүндрэл бэрхшээл байхгүй	14.3%	41.7%	45.8%	66.7%	100.0%
Гадаад хэлний бэрхшээл	-	-	3.4%	-	-
Хүний нөөц дутагдалтай байдал	14.3%	-	3.4%	-	-
Хотын төвөөс хол, замын түгжрэл	14.3%	8.3%	8.5%	9.5%	-

Өрөө тасалгааны халаалт муу	-	-	5.1%	4.8%	-
Ажиллах орчин тааруу	14.3%	-	1.7%	-	-
Орон сууцны хангамж муу, амьдрах нөхцөлийг сайжруулах	-	16.7%	8.5%	4.8%	-
Ажилчдын харилцаа хандлагын хүндрэл, ойлголцлын зөрүү	14.3%	-	6.8%	-	-
Ачаалал их	14.3%	8.3%	0.0%	4.8%	-
Зайнаас ажиллах боломжоор хангах	-	-	3.4%	-	-
Хангамж нэмэгдүүлэх, сайжруулах	-	-	1.7%	4.8%	-
Үйлчлүүлэгчдийн харилцаа, хандлага	-	16.7%	3.4%	-	-
Хууль тогтоомж	14.3%	-	1.7%	-	-
Программ хангамжийг сайжруулах	-	-	3.4%	-	-
Ажил үүргээ гүйцэтгэх явцын аюулгүй байдлын хангах	-	8.3%	-	-	-
Цайны өрөө байхгүй	-	-	-	4.8%	-
Амрах өрөө байхгүй	-	-	3.4%	-	-

Тулгарч буй хүндрэл бэрхшээлийг албан хаагчдын ажиллаж буй байршлаар нь харвал орон нутагт ажиллаж буй албан хаагчдын хувьд хүний нөөц болон орон байрны асуудлуудыг хамгийн их дэвшүүлсэн бол Улаанбаатар хотын албан хаагчдын хувьд хүндрэл бэрхшээл харьцангуй бага бөгөөд замын түгжрэл, ажлын байрны орчин нөхцөл гэм мэт асуудлууд тулгардаг байна.

Хүснэгт 8. Хүндрэл бэрхшээл, ажиллаж буй байршлаар


Хүндрэл бэрхшээл	Улаанбаатар	Баян-Өлгий	Говь-Алтай	Дархан-Уул	Дорнод	Дорноговь	Завхан	Өмнөговь	Сэлэнгэ	Увс	Ховд
Хүндрэл бэрхшээл байхгүй	53%	50%	-	100%	14%	80%	-	33%	71%	0%	38%

“ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР”-ЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2024

Гадаад хэлний бэрхшээл	-	-	100%	-	-	-	-	-	-	-	-
Хүний нөөц дутагдалтай байдал	-	-	-	-	-	-	-	67%	-	25%	-
Хотын төвөөс хол, замын түгжрэл	16%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өрөө тасалгааны халаалт муу	7%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ажиллах орчин тааруу	-	25%	-	-	14%	-	-	-	-	-	-
Орон сууцны хангамж муу, амьдрах нөхцөлийг сайжруулах	-	-	-	-	29%	20%	100%	-	-	25%	38%
Ажилчдын харилцаа хандлагын хүндрэл, ойлголцлын зөрүү	9%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ачаалал их	2%	-	-	-	-	-	-	-	14%	-	13%
Зайнаас ажиллах боломжоор хангах	3%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хангамж нэмэгдүүлэх, сайжруулах	-	-	-	-	-	-	-	-	14%	25%	-
Үйлчлүүлэгчдийн харилцаа, хандлага	5%	-	-	-	14%	-	-	-	-	-	-
Хууль тогтоомж	2%	25%	-	-	-	-	-	-	-	-	-
Программ хангамжийг сайжруулах	-	-	-	-	14%	-	-	-	-	-	13%
Ажил үүргээ гүйцэтгэх явцын аюулгүй байдлын хангах	-	-	-	-	-	-	-	-	-	25%	-
Цайны өрөө байхгүй	2%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Амрах өрөө байхгүй	2%	-	-	-	14%	-	-	-	-	-	-

04

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- 
- 4.1. ДҮГНЭЛТ
 - 4.2. ЗӨВЛӨМЖ
 - 4.3. ХАВСРАЛТ

ДҮГНЭЛТ

ГИХГ-аас үйлчилгээ авсан иргэд ААНБ-ын судалгааны дүгнэлт

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

- Судалгаанд оролцогчдын ГИХГ-ын талаарх мэдлэгийг үнэлэхэд 47.3% нь сайн гэж хариулсан бол 5.9% нь муу гэж хариулсан байна.
- Мэдээллийн хүртээмжтэй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээг үзэхэд бүх үзүүлэлт сайн гэсэн үзүүлэлтэд хүрэхгүй байгаа бөгөөд зөвлөгөө мэдээллийн утасны хүртээмж 3.3 буюу хамгийн бага оноогоор үнэлэгдсэн байна.
- Мэдээллийн нэмэлт эх сурвалжийн санал асуухад сошиал сувгууд болон чатбот, сургалт гэх мэт аргуудаар нэмэлт мэдээлэл авах хүсэлтэй байгаа бөгөөд веб хуудас болон лавлах утасны хүртээмжийг сайжруулах санал мөн түгээмэл ирсэн байна.
- Албан хаагчдын ес зүйн үнэлгээний хувьд хариуцлага шударга байдал болон мэдлэг ур чадвар гэх 2 үзүүлэлт сайн руу дөхсөн буюу 3.9 оноогоор үнэлэгдсэн байна.
- Албан хаагчдын ес зүйг үйлчилгээний төрлөөр харвал визний зөвшөөрлийн чиглэлийн үнэлгээ хамгийн өндөр оноотой байгаа бол харьяатын чиглэлийн үйлчилгээ хамгийн бага оноотой байна.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧИН

- Үйлчилгээний орчны хувьд цэвэрлэгээ үйлчилгээ, байгууллагын гадна доторх тэмдэг тэмдэглэгээ, машины зогсоолын хүртээмж гэх үзүүлэлтүүд нь хамгийн өндөр оноотой байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал гэх үзүүлэлт хамгийн бага үнэлгээтэй байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ШААРДЛАГА

- Иргэдийн хамгийн их авдаг үйлчилгээ бол виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээ бөгөөд судалгаанд оролцогчдын 92.2% нь тус үйлчилгээг авсан байна.
- Үйлчилгээ авахад зарцуулж буй цагийн хувьд маш асуудалтай буюу судалгаанд оролцогчдын 35.6% нь 1-с дээш өдрийг тухайн үйлчилгээг авахад зарцуулдаг байна. Нэн ялангуяа Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын ТББ-ын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх гэх 2 үйлчилгээг авахын тулд судалгаанд оролцогчдын 50-с дээш хувь нь 1-с дээш өдрийг зарцуулж байна.
- Үйлчилгээ авахад бүрдүүлж буй материалын хувьд харьяатын чиглэлийн үйлчилгээ авч байгаа иргэд дунджаар хамгийн олон тооны баримт бүрдүүлэх шаардлагатай болдог байна.

- Мөн дээрх баримтуудыг судалгаанд оролцогчдын 64.9% нь өөр өөр газраас бүрдүүлсэн бөгөөд дүүрэг хороодоос авах тодорхойлолт гэх мэт баримтуудыг бүрдүүлэхэд хамгийн их цаг зарцуулдаг байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ СЭТГЭГДЭЛ

- Үйлчилгээ авч буй иргэдийн хувьд хариу өгөх байдал удаашралтай, зөвлөгөө мэдээлэл авахад хугацаа их шаарддаг, бүрдүүлэх баримт бичиг яаж бүрдүүлэх нь ойлгомжгүй гэх мэт асуудлууд нь хамгийн түгээмэл тохиолддог байна.
- Мөн байгууллагын лавлах утас нь холбогдоход их хүндрэлтэй удаашралтайгаас гадна isf.mn систем нь цаг их авдаг мэдээ мэдээлэл нь ойлгомжгүй гэх мэт асуудлууд тулгардаг байна.
- Хүндрэл бэрхшээлийг үйлчилгээний чиглэлээр харвал харьяатын чиглэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичиг нь хаанаас авах нь ойлгомжгүй байдаг бол виз зөвшөөрлийн чиглэлийн үйлчилгээний хувьд хариу өгөх байдал удаашралтай байдаг нь хамгийн том хүндрэлүүд болдог байна.
- Виз зөвшөөрлийн үйлчилгээний чанарын дундаж үнэлгээ 3.5 байсан бол харьяатын чиглэлийн үйлчилгээнийх 3.5, зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үйлчилгээний дундаж үнэлгээ нь 3.6 гэж тус тус үнэлэгдсэн байна.
- Цахим үйлчилгээний хувьд дундаж үнэлгээ 3.61 буюу дундаж гэсэн үнэлгээтэй байсан бөгөөд систем гацдаг, алдаа заадаг, хэт их асуулт бөглүүлдэг, шийдвэрлэх хугацааны хувьд удаан, мэдээлэл дутмаг, файл хавсаргахад хүндрэлтэй гэх мэт асуудлууд дурдагдсан байна.
- Судалгаанд оролцсон иргэдээс цахим үйлчилгээг сайжруулах, түргэн шуурхай үйлчлэх, сургалт зохион байгуулах, бүх үйлчилгээг нэг дороос цахимаар авах боломжтой болгох гэх саналууд хамгийн түгээмэл ирсэн бол 26.8% нь санал хүсэлт байхгүй гэж хариулсан байна.

Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт

АЖЛЫН АЧААЛАЛ

- Судалгаанд оролцсон албан хаагчдын хувьд ачааллын үнэлгээний дундаж 3.5 байгаа бөгөөд Улаанбаатар болон Увс аймгийн албан хаагчид хамгийн бага оноогоор үнэлсэн бол Баян-Өлгий болон Дархан-Уул, Дорноговь аймгууд нь ажлын ачаалал бага гэж үнэлсэн байна.
- Ажлын ачааллыг албан тушаалаар нь харвал удирдах албан тушаалтан болон туслах ажилтнууд хамгийн бага ачаалалтай байгаа бол дунд шатны албан тушаалтнууд нь хамгийн өндөр ачаалалтай ажилладаг байна.

СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАЛ

- Судалгаанд оролцсон албан хаагчдын хувьд ажилдаа сэтгэл хангалуун байдаг бөгөөд сэтгэл ханамжтай байдлын дундаж үнэлгээ нь 4.3 оноотой байна.
- Мөн албан тушаалын түвшнээс үл хамааран бүгд сэтгэл ханамжтай байдаг бөгөөд туслах ажилтнуудын хувьд маш их сэтгэл ханамжтай байдаг гэж тодорхойлсон байна.
- Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулахад дийлэнх буюу 48% нь хүндрэл бэрхшээл байхгүй гэж хариулсан бол 9% нь хотын төвөөс хол, 8% нь орон сууцны хангамж муу, 5% нь ажилчдын харилцаа хандлага муу, 4% нь өрөө тасалгааны халаалт муу гэх мэт хариултуудыг тус тус илгээсэн байна.

ДЭЭД АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАА ХАНДЛАГА

- Дээд албан тушаалтны харилцаа хандлагын хувьд дундаж үнэлгээ нь 4.2 буюу сайн байсан бөгөөд эрхэлж буй албан тушаалаар нь харвал туслах ажилтнуудын хувьд маш сайн бол үйлчилгээний албан хаагчдын хувьд дундаж гэж үнэлэгдсэн байна.
- Дээд албан тушаалтны ур чадварын хувьд дундаж үнэлгээ нь мөн адил 4.2 байсан бөгөөд зөвхөн Дархан-Уул аймгийн албан хаагчид дундаж гэж үнэлсэн байна.

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

- Байгууллагын дотоод уур амьсгалын хувьд дундаж үнэлгээ 3.9 байсан бөгөөд Дорноговь, Говь-Алтай, Өмнөговь аймгийн албан хаагчид **5** буюу маш сайн гэж үнэлсэн бол Дархан-Уул аймгийн албан хаагчид **3** оноо буюу дундаж гэж үнэлсэн байна.
- Байгууллагын дотоод орчныг үнэлсэн албан хаагчдын ажиллаж буй байршилтай нь харьцуулаад харвал Дорноговь аймгийн албан хаагчид **4.8** буюу маш сайн гэж үнэлсэн бол Дархан-Уул аймгийн албан хаагчид **3** оноо буюу дундаж гэж үнэлсэн байна. Нийт албан хаагчдын өгсөн үнэлгээний дундаж оноо **4** буюу сайн гэсэн үнэлгээтэй байна. Байгууллагын дотоод орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг харвал ширээ сандал, гэрэлтүүлэг, компьютер тоног төхөөрөмж гэсэн үзүүлэлтүүд нь **4**-с дээш буюу сайн гэсэн үнэлгээтэй байгаа бол гал тогоо, чөлөөт

цагаа өнгөрөөх боломж гэсэн үзүүлэлтүүд нь 3 буюу дундаж гэсэн үзүүлэлттэй байна.

- Байгууллагын дотоод орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээг албан хаагчдын ажиллаж буй байршлаар нь харвал орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын хувьд гал тогоо болон чөлөөт цагаа өнгөрөөх боломж хомс бөгөөд хамгийн бага оноотой байгаа бол ширээ сандал болон компьютер тоног төхөөрөмж хамгийн өндөр оноотой байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

СУДАЛГААНЫ ТӨРӨЛ

1



Иргэд, ААНБ

- Лавлах утасны хүрэлцээ муу байдаг тул иргэдэд мэдээлэл өгөх операторын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Хугацаа тулсан үед жагсаалтад байхгүй материалыг нэмэлтээр нэхдэг асуудал гардаг тул бүрдүүлэх шаардлагатай материалын тоо болон хаанаас авахыг тодорхой болгож мэдээлэх.
- Иргэдийн хувьд материал бүрдүүлэлтийг цахимаар авах хүсэлтэй байдаг ч төрийн байгууллагын уялдаа холбоо муу байгаагаас шалтгаалан цахимаар авах боломжгүй болдог байна. Жишээлбэл
 - Нийгмийн даатгалын газрын шинэ цахим хуудас нь 3 жилийн тодорхойлолт олгохоо больсон. Иймд НД газар луу биеэр явж авах шаардлага гардаг.
 - Дүүрэг хороодоос оршин суугаа хаягийн тодорхойлолт очиж авах шаардлага гардаг.
 - Зарим ХХҮЕГ-т шалгуулсан бичиг баримтууд давхарддаг. Ялангуяа хөдөлмөр эрхлэлтэй холбоотой бүрдүүлэх бичиг баримтуудыг дахин авах шаардлага гардаг.
- Цахимаар үйлчилгээ авахад хариу үйлдэл маш удаан байдаг.
- Үйлчилгээний журам өөрчлөгдсөн тохиолдолд мэдээллээ түргэн шуурхай хүргэдэг байх.
- Мэдээллийн ажилтнуудын харилцааны асуудалд анхаарах
- Яаралтайгаар төлбөрөө төлж авч байгаа үйлчилгээг илүү хурдан хугацаанд шийдвэрлэдэг болох.
- Анх удаа ирж үйлчлүүлж байгаа иргэдэд зөвлөгөө өгөх үйлчилгээний ажилтантай болох.
- Цахим хуудсан дээрх бусад төрийн байгууллагууд руу нэвтрэх линкийг ажилладаг болгох.
- Хотын төвөөс хол байршилтай учир очиж үйлчлүүлж буй иргэдэд хүндрэлтэй байдаг.

Албан хаагч

- Орон нутагт ажиллаж буй албан хаагчдын хувьд орон байрны хангамж хүрэлцээ муу гэж дүгнэсэн бөгөөд энэхүү тал дээр арга хэмжээ авах.
- Ажлын ачааллын дундаж үнэлгээний хувьд Улаанбаатар хот болон орон нутгийн албан хаагчдын хувьд хангалтгүй дундаж үнэлгээтэй бөгөөд нэн ялангуяа Ховд, Дорнод, Сэлэнгэ, Завхан, Говь-Алтай гэх аймгуудын үнэлгээ хамгийн бага оноотой байгаа бөгөөд эдгээр аймгийн албан хаагчдын ачааллыг тэнцвэржүүлэх
- Улаанбаатар хотод ажиллаж буй албан хаагчдын хувьд ажлын байр нь хотын төвөөс хол түгжрэлд зарцуулах цаг маш өндөр байдаг тул гүйцэтгэх ажлын чиглэлээс нь хамаараад өдрийн зарим цагийг цахимаар ажиллах боломжийг бий болгох.
- Байгууллагын орчинд нөлөөлж буй хүчин зүйлсийн хувьд сандал ширээ, компьютер тоног төхөөрөмж гэх мэт зүйлс сайн гэсэн үнэлгээтэй байгаа хэдий ч албан хаагчдын чөлөөт цагаа өнгөрөөх боломж хомсоос гадна хооллоход тохиромжтой орчин байхгүй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймээс чөлөөт цагаа өнгөрөөх боломжийг нэмэгдүүлж цайны цагаар хооллоход тохиромжтой орчныг бий болгох шаардлагатай.

2



Виз зөвшөөрлийн чиглэл

- Санал гомдлын дагуу арга хэмжээг түргэн шуурхай авдаг байх.
- Санал гомдлын дагуу асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг хариу мэдээлдэг байх.
- Ажилтнуудын тоог нэмэгдүүлэх.
- Үйлчилгээний хариуг түргэн шуурхай өгдөг байх.
- Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хаанаас бүрдүүлэх талаар мэдээллийн хамт цуг хүргэдэг болох.
- Тухайн иргэний өмнөөс мэдээлэл бөглөж байгаа учир төгссөн сургууль, төрсөн газар, өмнө нь ажиллаж байсан байгууллага, гэр бүлийн гишүүд зэрэг мэдээллүүдийг олон дахин бөглөх хүндрэлтэй байдаг тул нэгдсэн байдлаар бөглөдөг байх.

- Санал гомдлоо илэрхийлэх боломжийг бий болгох.
- Үйлчилгээний ажилтнууд асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдвэрлэдэг болох.
- Үйлчилгээний талаар хариу өгөх байдал удаашралтай.
- Үйлчилгээ үзүүлж буй ажилчдын тоог нэмэгдүүлэх .

Харьяатын чиглэл

Зөрчил шалган шийдвэрлэх

- Ажилтнуудын тоог нэмэгдүүлэх.
- Санал гомдлыг хурдан хугацаанд шийдвэрлэж өгөх .
- Цаасаар бүрдүүлэх шаардлагатай материалууд хүндрэлтэй байдаг тул тэдгээрийг цахимаар бүрдүүлэх боломжийг хангаж төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.

- Санал, хүсэлтийг хүлээн авах цэс бий болгох. Цэс хэсэгт утга агуулгын хувьд адилхан олон төрлийн сонголттой байгаа нь иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэдэг.
- Цахим хуудасны цэсийг ойлгомжтой болгох. Жишээ нь мэдээлэл болон үйлчилгээ хэсгийг салгах. Мөн мэдээлэл хэсэгт материал бүрдүүлэх
- Системийн гацалтыг багасгах.
- Материал дахин дахин буцаагддаг байдлыг яагаад буцаагдсан шалтгааныг тайлбарладаг байх.
- Файлаа хавсаргах үйлдлийг илүү хялбар болгох. Зарим тохиолдолд файл хавсаргах товчлуур нь ажилладаггүй тул засварлах.
- Тоон гарын үсэг ашиглах нь хүндрэлтэй байдаг тул хэрэглэхэд тохиромжтой хялбар болгох
- Файл татаж авахад зургийн чанар мууддаг байдлыг засах.
- Бичиг баримтын зураг танилтыг сайжруулах.

Цахим үйлчилгээ

ХАВСРАЛТ

Хүснэгт 9. Албан хаагчдын судалгааны түүврийн задаргаа

№	Байршил	Тоо хэмжээ	Түүвэрт эзлэх хувь
1	Улаанбаатар	58	58.0%
2	Баян-Өлгий	4	4.0%
3	Говь-Алтай	2	2.0%
4	Дархан-Уул	1	1.0%
5	Дорнод	7	7.0%
6	Дорноговь	5	5.0%
7	Завхан	1	1.0%
8	Өмнөговь	3	3.0%
9	Сэлэнгэ	7	7.0%
10	Увс	4	4.0%
11	Ховд	8	8.0%
	Total	100	100.0%

Хүснэгт 10.. Үйлчилгээ авсан иргэн, ААНБ-ын түүврийн задаргаа

№	Байршил	Тоо хэмжээ	Түүвэрт эзлэх хувь
1	Улаанбаатар	187	91.2%
2	Баян-Өлгий	1	.5%
3	Дархан-Уул	3	1.5%
4	Дорноговь	2	1.0%
5	Дундговь	1	.5%
6	Орхон	1	.5%
7	Өмнөговь	2	1.0%
8	Сүхбаатар	1	.5%
9	Төв	4	2.0%
10	Хэнтий	3	1.5%
	Total	205	100.0%

ХОЛБОО БАРИХ:

Төв оффис: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Ж.Самбуугийн гудамж, Бльюмон оффис, 7 давхар

Утас: (976)-70126009

Факс: (976)-70126009